



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Додоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны аравдугаар сарын 14

№38 (515)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

502. "Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай" Монгол Улс,
Оросын Холбооны Улс хоорондын гэрээг соёрхон батлах тухай 961

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

503. Хөтөлбөр батлах тухай Дугаар 225 962
504. Урамшуулал олгох тухай Дугаар 227 969
505. Эрүүл мэндийн даатгалын 2008 оны шимтгэлийн
хэмжээг тогтоох тухай Дугаар 230 970
506. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан
тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 236 970
507. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 239 979
508. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн
тогтоох тухай Дугаар 240 979
509. Ахмад дайчдын орон сууцны тухай Дугаар 250 979
510. Хэлэлцээр батлах тухай Дугаар 254 980
511. Журам батлах тухай Дугаар 256 980
512. Хэлэлцээр батлах тухай Дугаар 258 983
513. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 263 984

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 10 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

**"МОНГОЛ-ОРОСЫН УЛСЫН ХИЛИЙН
ДЭГЛЭМИЙН ТУХАЙ" МОНГОЛ УЛС,
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ХООРОНДЫН
ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улс, Оросын газрын өргөн мэдүүлснээр соёрхон
Холбооны Улс хооронд 2006 оны 12 дугаар баталсугай.
сарын 8-ны өдөр байгуулсан "Монгол-Оросын
улсын хилийн дэглэмийн тухай" гэрээг Засгийн
**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Жендэрийн тэгш байдлын үндэсний хороонд, хариуцсан чиглэл тус бүрийнхээ арга хэмжээг эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын

холбогдох гишүүд, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж байхыг Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо, Сангийн сайд Н.Баяртсайханд тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Д.ОДБАЯР

Засгийн газрын 2007 оны 225 дугаар
тогтоолын хавсралт

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)-д заасан хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979), энэхүү конвенцийн нэмэлт протокол (1999), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцэд оруулах нэмэлт протокол (2000), түүнчлэн Хүний эрхийн талаархи 1993 оны Венийн, Хүн ам ба хөгжлийн асуудлаархи 1994 оны Кайрын, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжингийн бага хурлуудын шийдвэрүүдэд тусгагдсан гэр бүлийн гишүүн бүр аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг хангахад чиглэгдэнэ.

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар олсон амжилт

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаархи асуудлыг төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгайлан тусгаж, холбогдох олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсны зэрэгцээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх

тухай хуулийг 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр шинээр баталсан нь төрөөс энэ асуудлыг ихээхэн анхаарч, хүчин чармайлт гаргаж байгаагийн илрэл юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хохирогчийг хамгаалах арга, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах журам зэрэг асуудлыг зохицуулсан болно.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого (2003)-ын баримт бичигт гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүүхэд, эмэгтэйчүүд ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2004)-т гэр бүлд хууль зүй, сэтгэл зүйн болон амьжиргаагаа дээшлүүлэх зөвлөгөө өгөх, шаардлагатай үед гэр бүлийн гишүүдийг хүчирхийлээс хамгаалах түр байр ажиллуулах зэрэг үйлчилгээний сүлжээ бий болгох нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах нэг үр дүн байхаар заасан.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003)-т эмэгтэйчүүд гэр бүлийн харилцаанд тэгш оролцоход нь үзүүлэх нөлөөллийг үнэлэх шалгуурыг боловсруулан нэвтрүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй

эмэгтэйчүүд, хүүхдийг асран хамгаалах талаар гүйцэтгэх эрх мэдлийн зохих байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхээр заасан.

Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо байгуулагдан, орон тооны ажлын албатайгаар тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд үүсэн байгуулагдаж, энэ чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх зэргээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг идэвхтэй дэмжин ажиллаж байна.

Хүчирхийлэлд өртөгсдийг түр хамгаалах байрны зарим үйлчилгээг төрийн бус байгууллага бие даан хэрэгжүүлж, төрийн байгууллага үүнийг нь санхүүжүүлж, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төрийн болон төрийн бус байгууллага хамтдаа тэмцэж эхэлсэн зэрэг нааштай алхмууд хийгдэж байна.

1.2. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага

Хун амьдралынхаа андагч орчин болох гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид, эрүүл саруул, аюулгүй орчинд эрх тэгш амьдрах эрхтэй бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил мөн.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд зохих нөлөө үзүүлэх болно. Хүчирхийлэл бүхий нөхцөлд байгаа хохирогчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг нэн түргүүнд анхааран үзэж гэр бүлийн хүчирхийллийн уршигт үр дагаврын нэг болох эрүүл мэнд, эрхтэн тогтолцооны бүрэн бүтэн байдал алдагдах, ойр дотны хүмүүсийнхээ гарт амь үрэгдэх явдлаас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Гэр бүлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, сэтгэл засал, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хувь хүнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, гэр бүлийн нөхцөл байдалд тохирсон тусламж, дэмжлэг үзүүлэх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, хөгжлийн онцлогийг харгалзсан өвөрмөц хэрэгцээнд тохируулахын зэрэгцээ тэдний нийтлэг эрх ашигт суурилсан цогц үйлчилгээг хүртээмжтэйгээр, мэргэжлийн түвшинд үзүүлэх шаардлага гай юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинээр батлагдаж, хүчин төгөлдөр

мөрдөгдөж байгаа боловч уг хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт ороогүйн улмаас эрх зүйн иж бүрэн зохицуулалт бүрдээгүй байна.

Хууль тогтоомжийн харилцан уялдааг ханган, бие биеэ дэмжсэн цогц зохицуулалт бий болгох нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүхий л үйл ажиллагааны хүрээнд үр дүнгээ үзүүлэх юм. Иймээс эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн болон хувь хүний ухамсар, хүмүүжил, үзэл хандлагатай шууд хамааралтай бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн зарим үйлдлийг нийгмийн аюултай үзэгдэл бус зөвхөн тухайн гэр бүлийн дотоод асуудал, гарцаагүй хэрэглэх арга мэтээр хүлээн авах явцуу ойлголт нийгэмд тодорхой хэмжээнд оршоор байна.

Эрх нь эерчигдөж байгааг хохирогч гэр бүр ухамсарлахгүй, гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, хүчирхийлэгчид хүлээлгэх хариуцлагын талаархи мэдлэг дутмаг байна. Гэр бүлийн хүчирхийлэлгүй орчин бүрдүүлэх гол хүчин зүйл нь эрх гэрийн ёс заншил, өв уламжлал, үнэт зүйлийг эрхэмлэх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах, бие биенээ хүндлэх замаар гэр бүлийн гишүүдийн ухамсар, соёлыг дээшлүүлэхэд оршино.

Иймээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг өргөн хүрээнд авч үзэн эцэг, эхийн үүрэг, хариуцлага болон хүүхдийн хүмүүжил, телевизийг сайжруулах, гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр нухацтай анхааран ажиллах шаардлага тулгарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар гол үүрэг хариуцлага хүлээх төрийн байгууллагуудын тусгай үүрэг хариуцлагыг тодорхой заасан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм хангалттай бүрдээгүй, энэ төрлийн хүчирхийлэл бий болж байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга зүй, чадавхи дутмаг, үндэсний бусад төрөлжсөн хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгүүдтэй уялдуулах нэгдмэл удирдлага, зохицуулалт бүрдээгүйгээс салбар хоорондын ажлын уялдаа холбоо хангагдаж чадахгүй байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих асуудал чухлаар тавигдаж байна.

Хүчирхийллийн тархалтын талаархи судалгаа, статистикийн мэдээ баримтжуулалт хангалтгүй байгаа нь хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүчин чармайлтыг сааруулахад нөлөөлж байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн

тохиолдлыг бүртгэх тодорхой журам, стандартыг цагдаа, шүүх, эрүүл мэндийн байгууллагад мөрдүүлж, мэдээллийг тогтмол цуглуулж, эргэн мэдээлэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх талаар хамтран ажиллах нь үр дүнтэй юм.

Хуулийн болон эрүүл мэндийн байгууллага, нийгмийн ажилтнуудын гэр бүлийн хүчирхийллийн хохирогчидтой ажиллах үр чадвар дутмаг, эерэг хандлага төлөвшөөгүй, чирэгдэл ихтэй зэрэг нь хохирогчид холбогдох байгууллагуудад хандахгүй, гэр бүлийн хүчирхийлэл дарагдан өнгөрөх нөхцөлийг бүрдүүлдэг тул хүний нөөцийг чадавхижуулах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл нь нийгмийн хурц асуудал болохын хувьд түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн оролцооноос гадна иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн хүчин чармайлт нэн чухал болно.

Хоёр. Хөтөлбөрийн эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, үндсэн зарчим

2.1. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь гэр бүлийн гишүүд хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангаж, гэр бүлийн хүчирхийлэл үүсэн гарч байгаа шалтгаан нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгахад оршино.

2.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь хоорондоо харилцан уялдаа бүхий дараахь тэргүүлэх чиглэлтэй байна.

2.2.1. Хамгаалах

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн дараа өртөх эрсдэл, болзошгүй аюул заналаас хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хүний эрхэд суурилсан эрх зүйн таатай орчин, бодлого, удирдамжийг бэлэвсруулан хөгжүүлэх.

2.2.2. Үйлчилгээ үзүүлэх

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн хэрэгцээ, сонирхол нэгдэн тохирсон цогц үйлчилгээ үзүүлэх нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг сайжруулан хөгжүүлэх.

2.2.3. Урьдчилан сэргийлэх

Олон нийтэд урт болон богино хугацааны бэлэвсрэл олгох албан ба албан бус хяналтбэрээр

дамжуулан гэр бүлийн хүчирхийллийг эсэргүүцэх, үл тэвчих ойлголт, мэдлэг, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, зан үйл, хандлагыг эерэг өөрчлөлтийг бий болгохыг дэмжих.

2.3. Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

2.3.1. Аюулгүй байдлыг дээдлэн хангах зарчим

Гэр бүлийн гишүүд аюулгүй орчинд, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг тэргүүн ээлжинд анхаарч үзнэ.

2.3.2. Нийтлэг эрх, онцлог хэрэгцээнд суурилах зарчим

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэр бүлийн бусад гишүүдийн нийтлэг эрх ашиг болон онцлог хэрэгцээнд нийцсэн байна.

2.3.3. Салбар хоорондын зохицуулалтаар хангах зарчим

Харилцан хамааралтай, уялдаа холбоотой нь авч үзсэн нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхдээ салбар хоорондын зохицуулалтаар хангана.

2.3.4. Оролцооны зарчим

Хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг бүхий л үйл ажиллагаа нь гэр бүлийн гишүүд болон олон нийтийн оролцоонд тулгуурлана.

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилт, хүрэх үр дүн, арга хэмжээ

A. Гэр бүлийн хүчирхийллийг шуурхай таслан зогсоох механизмын хүрээ

Зорилт 1

Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох механизмыг бий болгон хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн 1.1

Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд мэргэжлийн түвшинд шуурхай хамгаалагдах баталгаа бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1.1. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах тухай шүүхийн шийдвэрийг шүүхээс нэн даруй гаргах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

1.1.2. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх механизмыг тодорхой, боловсронгуй болгон хөгжүүлэх.

Хүрэх үр дүн 1.2

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох үйл ажиллагаа нь стандартчилгагдан журамлагдсан байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогч, гэр бүлийн бусад гишүүдтэй ажиллах удирдамж, стандартыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагууд дангаараа болон хамтран боловсруулж, мөрдөх;

1.2.2. Алслагдсан бүс нутгийн ард иргэд болон үндэстний цөөнхийн дунд гарч буй гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний онцлог хэрэгцээг судалсны үндсэн дээр холбогдох удирдамжийг боловсруулж мөрдүүлэх.

Хүрэх үр дүн 1.3

Хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох мэргэжлийн үйлчилгээг үндэсний хэмжээнд шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэг болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.3.1. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байрны сүлжээг үндэсний хэмжээнд бий болгох ажлыг зохион байгуулах;

1.3.2. Гэр бүлд мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа өгөх зорилгоор 24 цагийн утасны үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох;

1.3.3. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийг буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

1.3.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх асуудлыг иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор судалж, турших.

Б. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажлын үйлчилгээний хүрээ

Зорилт 2

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид болон тэдний гэр бүлд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн 2.1

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн ажлын цогц үйлчилгээг үзүүлэх төр ба иргэний нийгмийн

байгууллагын салбар хоорондын сүлжээт тогтолцоо бий болж, хамтран ажиллах чадавхи, бүтэц, зохион байгуулалтын механизм бэхжиж, боловсронгуй, тодорхой, хүртээмжтэй болно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.1. Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлыг эрхлэх төрийн бус байгууллага, ажилтныг зохих шалгуур үзүүлэлт, нөхцөл, болзлын дагуу сонгон шалгаруулах тогтолцоог бий болгож, эдгээр байгууллага, ажилтны ажлын байрны тодорхойлолт, эрх, үүргийг баталгаажуулан магадлан итгэмжлэх;

2.1.2. Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн зрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах замаар чадавхижуулж нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх;

2.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажлын үйлчилгээний үр нөлөөний судалгааг хийх.

Хүрэх үр дүн 2.2

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийллээс ангижрах урт, богино хугацааны нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээг хүртэх таатай орчин бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.1. Хохирогчид шаардлагатай урт, дунд ба богино хугацааны нийгмийн ажлын үйлчилгээг ялгамжтайгаар тодорхойлох талаар судалж, удирдамж, заавар боловсруулан үндэсний хэмжээнд нэгдсэн журмаар мөрдүүлэх механизм бий болгох;

2.2.2. Хохирогч, тэдний гэр бүлийнхэнд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг давтан бэлтгэх, их, дээд сургуулийн хичээлд нэмэлт хөтөлбөр боловсруулж оруулах талаар судалж, шийдвэрлэх.

Зорилт 3

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нийгмийн ажлын үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн 3.1

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх арга, хэлбэр тодорхойлогдож, тодорхой загвар бий болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.2. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сэтгэл засал зөвлөгөө өгөх.

чадавхижуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжин хамтарсан төсөл хэрэгжүүлэх.

Зорилт 4

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн эрх ашигт нийцсэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн 4.1

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд тусгайлсан цогц үйлчилгээг хүргэж, хүчирхийллээс хамгаалах нөхцөл боломж бүрдэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархац, тандалтын талаархи судалгааг тогтмол хийж;

4.1.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг бууруулахын тулд уг асуудлын учир шалтгаан, хүрээ, нийгэм, эрх зүйн үйлчилгээг хэрхэн хүртэж байгаа талаархи мэдээлэл судалгааны сэнг үндэсний хэмжээнд бүрдүүлэх;

4.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүгч, багш гэх мэт холбогдох мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэж, хүний нөөцийг чадавхижуулах;

4.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд зохицуулан нийгмийн ажлын болон нөхөн сэргээх сэтгэл зүйн үйлчилгээний удирдамж, зааврыг тусгайлан боловсруулах, гарын авлага, зөвлөмжөөр хангах.

Зорилт 5

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн 5.1

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий бүлгийг тусгайлан хүчирхийллээс хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн албан хаагч болон нийгмийн ажилтан тухайн гэр бүлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа эсэхийг тодруулж, тэдэнд шаардлагатай нийгмийн ажлын үйлчилгээг тусгайлан үзүүлэх арга хэмжээ авах.

5.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нийцсэн нийгмийн

үйлчилгээний удирдамж, стандартыг боловсруулж мөрдүүлэх.

В. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчны хүрээ

Зорилт 6

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн 6.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж харилцан уялдаж, боловсронгуй болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

6.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэх зэрэг шаардлагын үүднээс зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

6.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний, Захираганы хариуцлагын, Иргэний бүртгэлийн болон Тэмдэгтийн хураамжийн зэрэг бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

6.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх олон улсын баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр Монгол Улс нэгдэн орох талаар санал, дүгнэлт боловсруулан шийдвэрлүүлэх.

Хүрэх үр дүн 6.2

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулийн талаар нэгдсэн ойлголт бий болж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил тогтмолжсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

6.2.1. Холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор тогтмол зохион байгуулах.

6.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн хэрэгжилтийн байдал, цаашид анхаарах асуудлын талаархи зөвлөмж, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

6.2.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулийн шинжлэх ухааны тайлбар гаргаж нийтийн хүртээл болгох арга хэмжээг зохиох байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлэх.

Г. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажиллагааны хүрээ

Зорилт 7

Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн ухамсрыг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн 7.1

Гэр бүлийн гишүүд бие биенээ хүндэтгэх, хүчирхийлэлгүй аж төрөх хандлага нийгэмд тодорхой хэмжээнд төлөвшинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар олон нийтэд зориулсан ухуулга сурталчилгааны стратегийг боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.2. Олон нийтэд зориулсан албан бус сургалт, сурталчилгааны ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах;

7.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ойлголт, мэдлэг, хандлага, ухамсрыг дээшлүүлэх, энэ талаархи хууль тогтоомжийг сурталчлахад зориулсан зөвлөмж, гарын авлага, материалуудыг боловсруулах чиглэлээр төрөл бүрийн мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн баг бүрдүүлэн ажиллах;

7.1.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх;

7.1.5. Гэр бүлийн харилцааны болон гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгааг хийх;

7.1.6. Монгол гэр бүлийн дэвшилтэт өв уламжлал, ёс заншлыг өвлүүлэн гэр бүлийн үнэлэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах.

Хүрэх үр дүн 7.2

Хамт олон, хөрш зэрэг нийгмийн бичил хэсэг нь хүчирхийлэлд өртөгсдөд мэдрэмжтэй, хариуцлагатай хандах ухамсар төлөвшинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.2.1. Хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар зорилтот бүлэг, олон нийтэд зориулсан гарын авлагыг бэлтгэн түгээх;

7.2.2. Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд эргэлтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг сонгон хэрэгжүүлэх.

7.2.3. Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүчирхийлэл, жендэрийн талаархи судалгааны үр дүн, зөвлөмжийг танилцуулах, сурталчлах зэрэг арга замаар гэр

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хандлагыг төлөвшүүлэх;

7.2.4. Шинээр гэр бүл бологсдод зориулан гэр бүлийн үүрэг, хариуцлага болон жендэрийн харилцааны чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

7.2.5. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт гэр бүлийн хөгжил, хүчирхийлэлгүй аж төрөх харилцааны асуудлыг тусгах.

Хүрэх үр дүн 7.3

Гэр бүлд хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшин гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.3.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх зорилго бүхий ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

7.3.2. Хохирогчийг чадавхижуулахад чиглэсэн ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

Д. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхийн хүрээ

Зорилт 8

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд салбар хоорондын зохицуулалтыг хангах үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

Хүрэх үр дүн 8.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаархи салбар хоорондын зохицуулалтыг хангахад чиглэсэн болон мэргэшсэн үндэсний тогтолцоо бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

8.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг данан хариуцаж, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий нэгжийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны бүтцэд үүсгэн байгуулах;

8.1.2. 8.1.1-д заасан нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх орон тооны бүтцийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын албанд бий болгох.

8.1.3. Гэр бүлийн хэргийг шийдвэрлэх чиглэлээр шүүгчдийг мэргэшүүлэх, дагнасан шүүхийг бий болгох асуудлыг судлах.

8.1.4. Цагдаагийн байгууллагын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг бий болгох асуудлыг судлах.

Зорилт 9

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр салбарын болон орон нутгийн хооронд

мэдээлэл байнга солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн 9.1

Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээ, материалыг холбогдох эх сурвалжаас цуглуулах, хэрэглэгчдэд мэдээлэх боломжтой болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

9.1.1. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи мэдээллийг цуглуулж сан бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх;

9.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай маягт, бүртгэлийг эрх бүхий байгууллагуудаас баталж мөрдүүлэх;

9.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенциудын хороодоос өгсөн зөвлөмж болон түүнийг хэрэгжүүлэх ажлын үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах.

Зорилт 10

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн 10.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирч, хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

10.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэх шүүгч, прокурор, цагдаа, өмгөөлөгч, сэтгэл зүйч, эрүүл мэнд, боловсролын байгууллагын ажилтан болон салбарын бодлого боловсруулагч мэргэжилтнүүдэд хууль тогтоомжоор хүлээлгэсэн нийтлэг болон тусгай үүрэгтэй нь холбогдуулан цогц сургалтыг тогтмол зохион байгуулах;

10.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаархи судалгааны ажлыг хөгжүүлэн, эрдэмтэд, судлаачдыг өргөнөөр оролцуулах;

10.1.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаархи төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, санхүүжүүлэх арга хэрэгслийг бүрдүүлэх.

10.1.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажил, үйлчилгээний чанарт хяналт тавьж, үр дүнг нь үнэлж дүгнэн, сайжруулах нэгдсэн стандарт боловсруулж мөрдөх.

10.1.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн санал санаачилгыг дэмжин, хөрөнгө нөөцийг бүрдүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргасан бусад хөтөлбөртэй уялдуулан зохицуулна.

4.2. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын яамд, холбогдох бусад байгууллагын хийх ажлыг тусгасан үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтийг удирдан зохион байгуулна.

4.3. Монгол Улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын ба бусад түншлэлийн байгууллага, иргэдтэй энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

4.5. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого болон Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилттой нийцүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн нөөц боломж, хамтын ажиллагааны хүрээнд үе шаттайгаар зохион байгуулна.

4.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа хүн ам, нийгмийн бүлгүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил, нийгмийн халамж, хамгаалал, өсвөр үеийн оролцоо, хүний эрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулан зохицуулна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, тайлан мэдээлэл

5.1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт болон Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын хугацаатай уялдуулан хөтөлбөрийг 2007-2015 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.1. Эхний үе шат нь 2007-2009 оныг хамаарах бөгөөд энэ үеийн үнэлгээгээр хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.1.2. Хоёр дахь үе шат нь 2010-2012 оныг хамаарах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн завсрын үнэлгээг хийж, цаг үеийн нөхцөл байдалд

тохируулан хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.1.3. Гурав дахь үе шат нь 2013-2015 оныг хамааруулан хэрэгжүүлж, хөтөлбөрийн эцсийн үр дүнг тооцно. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн гаргаж, олсон амжилт, туршлага, авсан сургаамжид үнэлгээ өгнө.

5.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.2.1. Улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

5.2.2. Хандивлагч орон болон олон улсын байгууллагын тусламж, хандив;

5.2.3. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

5.2.4. Хууль тогтоомжоор хорилоогүй бусад эх үүсвэр.

5.3. Хөтөлбөрийн санхүүжилт:

5.3.1. Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаанд зориулсан төвлөрсөн арга хэмжээний санхүүжилтийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

5.3.2. Санхүүжилтийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын албаны төсөвт тусгана.

5.4. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, хандивлагч орны шугамаар олгосон хандив, тусламж, түүнчлэн гэр бүл, олон нийт, иргэдийн үүсгэл санаачилга, оролцоотойгоор хуримтлуулсан хөрөнгийн эх үүсвэртэй холбоотой хөтөлбөрийн санхүүжилтийн тайланг сум, дүүрэг, аймаг, нийслэл болон үндэсний хэмжээнд тогтмол мэдээлж, хандивлагч, гүйцэтгэгчийн үйл ажиллагааг жил тутам шударгаар үнэлэн урамшуулах ажлыг зохион байгуулна.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Яамд болон бусад байгууллага нь энэхүү хөтөлбөрийн холбогдох арга хэмжээ тус бүрийнхээ хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонд хүргүүлснээр тус хороо хөтөлбөрт бүхэлд нь нэгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.2. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг жил бүр Засгийн газарт танилцуулж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгнө.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгмийн байгууллага, иргэдийг өргөнөөр оролцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1.5, 26.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Буудайн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор буудай үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас дотоодын гурилын үйлдвэр, Тариалан эрхлэлтийг дэмжих санд нийлүүлсэн стандартын шаардлага хангасан хүнсний буудайн тонн тутамд 60.0 (жаран) мянган төгрөгийн урамшуулал олгосугай

2. Урамшуулалд олгох хөрөнгийг Тариалан эрхлэлтийг дэмжих санд хуваарилагдсан хөрөнгөөс гаргахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагвад зөвшөөрсүгэй.

3. Хүнсний буудайн үйлдвэрлэлийг дэмжих, урамшууллын хөрөнгийг зарцуулах, түүнд

хяналт тавих, тайлагнах журам"-ыг баталж мөрдүүлэхийн зэрэгцээ урамшуулалд олгох хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва нарт даалгасугай.

4. Буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, гурилын хангамжийг хэвийн байлгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг жил бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагвад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Д.ТЭРБИШДАГВА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын 2008 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2008 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувь байхаар тогтоосугай.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагч болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн

даатгалын сарын хураамжийг 500 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын хураамжийг 4000 төгрөгөөр тус тус тогтоож 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын 2007 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 91 дүгээр тогтоолыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.ТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 7.10, 9.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтын ёсоор, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 2 дугаар хавсралтын ёсоор, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 3 дугаар хавсралтын ёсоор, бага, дунд боловсрол олгох сургууль, цэцэрлэгийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 4 дүгээр хавсралтын ёсоор, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 5 дугаар хавсралтын ёсоор, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 6 дугаар хавсралтын ёсоор, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон

төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг 7 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолоор баталсан албан тушаалын ангилал, зэрэглэлд нийцүүлэн байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоож 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Ерөнхий менежер нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХОДӨЛМӨРИЙН САЙД

Д.ДЭМБЭРЭЛ

Засгийн газрын 2007 оны 236 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

Төрийн захиргааны албан тушаалын ангилал	Тусгай ангилалд хамаарах төрийн захиргааны албан тушаал, тэдгээргийг адиртгах албан тушаал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын гоём тодорхойлолт	Төрийн захиргааны албан тушаалын зэрэглэл	Төрийн захиргааны албан тушаалын бүлэг, нэр	
				Төрийн захиргааны байгууллагын	Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал
A	1	2	3	4	5
ТЭРГҮҮН ТҮШМЭЛ	Яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адиртгах албан тушаал	Засгийн газрын үйл ажиллагааны зохиц сэлбэр, хүрээний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын ажлын гүйцэтгэл, үр дүнг төсвийн Ерөнхийлөн захиргааны өмнө харууцаж байгууллагын төсөв болон төрийн тусгай сангийн ашиглалтын талаар харуудлага гүйцэтгэнэ.	T3-14	1 Яамны Төрийн нарийн бичгийн дарга	
			T3-13	1 Засгийн газрын агентлагийн дарга	1 Нийслэлийн Засаг даргын орлогч 2 Улаанбаатар хотын ерөнхий менежер 3 Чөлөөт бүсийн захиралч
ЗЭРЭГЛЭСЭН ТҮШМЭЛ	Яамны газрын дарга, түүний орлогч, тэдгээргийг адиртгах албан тушаал	Засгийн газрын үйл ажиллагааны зохиц сэлбэр, хүрээний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын бүтцийн нэгжийг удирдаж, бодлогын тодорхой чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэнэ, үр дүнг тэргүүн түшмэлийн өмнө харууцна.	T3-12	1 Яамны газрын дарга 2 Засгийн газрын агентлагийн дэд дарга 3 Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дарга	1 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 2 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга 3 Аймгийн Засаг даргын орлогч 4 Чөлөөт бүсийн ерөнхий менежер
			T3-11	1 Яамны газрын орлогч дарга	1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 2 Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
			T3-10	1 Намны хэлтсийн дарга 2 Засгийн газрын агентлагийн газрын дарга 3 Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын дэд дарга	1 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга 2 Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга 3 Чөлөөт бүсийн захиралчийн ажлын албаны болон газрын дарга
АМЛАХ ТҮШМЭЛ	Яамны газрын дарга, агаар мэдээллийн, гэрээтэй зориулалттай албан тушаал	Засгийн газрын үйл ажиллагааны зохиц сэлбэр, хүрээний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын бүтцийн нэгжийг удирдаж, бодлогын тодорхой чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэнэ, үр дүнг тэргүүн түшмэлийн өмнө харууцна.	T3-9	1 Яамны тасгийн дарга 2 Засгийн газрын агентлагийн хэлтсийн дарга	1 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга 2 Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дэд дарга 3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга 4 Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга 5 Дүүргийн Засаг даргын орлогч 6 Чөлөөт бүсийн захиралчийн ажлын албаны хэлтсийн дарга
			T3-8	1 Намны дэлгэц нэгжжигдэн 2 Засгийн газрын агентлагийн үйлдлийн хэлтсийн дарга 3 Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын нэгжийн дарга	1 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга 2 Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга 3 Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 4 Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга 5 Сумын Засаг даргын орлогч 6 Тусгай хяналалтай хамааруулах үйлдвэрлэлийн захиргааны дарга 7 Чөлөөт бүсийн захиралчийн ажлын албаны тэргүүн дарга

A	1	2	3	4	5
ДЭС ТҮШМЭЛ Үйлэвэрлэлийн, гэрээтэй үйлдвэр, хэв маяг Үйлэвэрлэлийн, гэрээтэй үйлдвэр, хэв маяг	Үйлэвэрлэлийн, гэрээтэй үйлдвэр, хэв маяг	Засгийн газрын үйл ажиллагааны зохицол, хүрээнд төрөөрөө асуудлаар бодлого боловсруулах, хэрэгжлийг зохицуулах үүрэг хүлээж, ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэлсэн түшмэлийн өмнө хариуцна	T3-7	1. Яамны мэргэжилтэн 2. Засгийн газрын агентлагийн ахлах мэргэжилтэн 3. Засгийн газрын агентлагийн улсын байцагч	1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн 2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын тасгийн дарга 3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга 4. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга 5. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн дарга 6. Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга 7. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга 8. Улсын зэрэглэлтэй хотын захиралчдын ажлын албаны дарга 9. Чөлөөт бүсийн захиралчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн
			T3-8	1. Яамны туслах мэргэжилтэн 2. Засгийн газрын агентлагийн мэргэжилтэн 3. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын ахлах мэргэжилтэн	1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн 2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн 3. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн 4. Улсын байцагч 5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн 6. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн 7. Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн 8. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга 9. Чөлөөт бүсийн захиралчийн ажлын албаны мэргэжилтэн
			T3-9	1. Яамны Төрийн нарийн бичгийн даргын туслах 2. Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллагын мэргэжилтэн	1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн 2. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн 3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн 4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн 5. Улсын зэрэглэлтэй хотын захиралчийн ажлын албаны мэргэжилтэн 6. Аймгийн зэрэглэлтэй хотын захиралчийн ажлын албаны дарга 7. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга 8. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн дарга 9. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн
			T3-10	1. Засгийн газрын агентлагийн даргын туслах	1. Аймгийн зэрэглэлтэй хотын захиралчийн ажлын албаны мэргэжилтэн 2. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга 3. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн дарга

A	1	2	3	4	5
ТУСЛАХ ТУШААЛ	Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, гүйцэтгэл эрхлэх албан тушаал	Бодлого боловсруулахад дамжлаг үзүүлэгчид мэдээллийг суваалдан судалж, задлан шинжилгээ хийж, гүйцэтгэсэн ажлын чанарын талаар харууллага хүлээнэ. Нийтлэг үйлчилгээний ажилтан нарын үйл ажиллагааг эсхэлэн байгуулах үүрэг хүлээнэ.	ТЗ-3		1. Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн 2. Хорооны нийгмийн ажилтан 3. Сумын газрын дамжлагч 4. Сумын нийгмийн ажилтан
			ТЗ-2		1. Байгаль хамгаалагч 2. Хорооны эрхлэн байгуулагч
			ТЗ-1		1. Бэлтгэл нийгмийн ажилтан, зохион байгуулагч

Засгийн газрын 2007 оны 236 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын төрч тодорхойлолт	Зэрэглэл	Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаал
	1	2	3	4
1	Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮШУ-7	1. Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч
2			ТҮШУ-6	1. Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга
3			ТҮШУ-5	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал 2. Шинжлэх ухааны академийн орлогч дарга
4			ТҮШУ-4	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга 2. Төв /төрийн өмчт хуулийн этгээд/-ийн дарга 3. Шинжлэх ухааны академийн хэлтсийн дарга
5	Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮШУ-3	1. Эрдэм шинжилгээний ажилтан
6			ТҮШУ-2	1. Шинжлэх ухааны академийн мэргэжилтэн 2. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн инженер
7	Төхөөрөлийн гүйцэтгэл эрхлэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилгыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮШУ-1	1. Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан

Засгийн газрын 2007 оны 236 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Туслах ангилалд хяналдах албан тушаалын үндэслэл үнэмлэхүй гэрээтэй	Зэрэглэл	Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаал	Удирдах албан тушаалтай дүүжүүлэн жишээ мэргэжлийн албан тушаал
1	2	3	4	5	6
1			ТҮМБ-9	1. Их сургуулийн захирал	
2			ТҮМБ-8	1. Дээд сургуулийн захирал 2. Их сургуулийн дэд захирал	1. Их сургуулийн профессор
3			ТҮМБ-7	1. Дээд сургуулийн дэд захирал 2. Коллежийн захирал 3. Их сургуулийн Факультет /сургууль-ийн захирал /дасан/	1. Их сургуулийн дэд профессор 2. Дээд сургуулийн профессор
4		Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагын удирдах, эрх зорионолын хургад шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮМБ-6	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирал	1. Дээд сургуулийн дэд профессор 2. Коллежийн профессор 3. Их сургуулийн ахлах багш
5			ТҮМБ-5	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дэд захирал	1. Коллежийн дэд профессор 2. Их сургуулийн багш 3. Дээд сургуулийн ахлах багш
6			ТҮМБ-4	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын менежер	1. Дээд сургуулийн багш 2. Их сургуулийн дэддасалчин багш 3. Коллежийн ахлах багш
7		Төрийн үйлчилгээний мэргэжил, гэлтээс, үр өдөөд, гуршилдаг шийдвэр эрхэлдэг, туслах мэргэжлээр бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах сонин, зөвлөмж сургах үүрэг бүхий албан тушаал	ТҮМБ-3	1. Коллежийн багш 2. Дээд сургуулийн дардасалчин багш 3. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн багш	
8			ТҮМБ-2	1. Коллежийн дэддасалчин багш	
9			ТҮМБ-1	1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйлчилгээний дардасалчин	

Засгийн газрын 2007 оны 236 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГУУЛЬ,
ЦЭЦЭРЛЭГИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН
АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ**

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын товч тодорхойлолт	Зэрэглэл	Бага, дунд боловсрол олгох сургууль, цэцэрлэгийн төрийн үйлчилгээний албан тушаал
	1	2	3	4
1	Удирдах албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮБД-9	1. Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн захирал
2			ТҮБД-8	1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал 2. Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн сургалтын ерөнхий менежер
3			ТҮБД-7	1. Цэцэрлэг, яслийн эрхлэгч 2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер
4	Мэргэжлийн албан хаагч	Тодорхой нарийн мэргэжил, авъяас, ур чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн мэргэжлээрээ бие даан ажилладаг буюу удирдлагын шийдвэр гаргахад шаардагдах санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-6	1. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн арга зүйч
5			ТҮБД-5	1. Ерөнхий боловсролын сургуулийн багш 2. Цэцэрлэг, яслийн арга зүйч 3. Цэцэрлэг, яслийн багш
6			ТҮБД-4	1. Ерөнхий боловсролын сургуулийн эмч 2. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан 3. Цэцэрлэг, яслийн эмч 4. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан 5. Ерөнхий боловсролын сургуулийн дадлагын багш
7			ТҮБД-3	1. Дотуур байрны хүмүүжүүлэгч 2. Хичээлийн зохицуулагч
8	Техникийн гүйцэтгэх албан хаагч	Байгууллагын үйл ажиллагаа, зорилтыг биелүүлэхэд тодорхой мэргэжил, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэх үүрэг бүхий албан тушаал	ТҮБД-2	1. Цэцэрлэг, яслийн туслах багш
9			ТҮБД-1	1. Цэцэрлэг, яслийн тогооч 2. Ерөнхий боловсролын сургуулийн номын санч

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд хамаарах албан тушаалын тэснүүдийн нийт	Ангилал	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал	Хүндэтгэн албан тушаалтай дийлүүлэн ялган маргажлийн албан тушаал
	1	2	3	4	5
1.	Үйлдвэр, ажлаар үйлдвэр	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, арга зохионоороо хуралд хяндар гаргадаг албан тушаал	ТҮСМ-9	1. Улсын өмчийн болон төрөлхөн маргажлийн зөвлөлийн дарга, захирал 2. Бусийн өмчлөлт, зөвлөхөөр төрийн дарга 3. Улсын өмчийн рашаан сууцлын дарга	
2.			ТҮСМ-8	1. Улсын өмчийн болон төрөлхөн маргажлийн зөвлөлийн орлогч дарга, дэд захирал 2. Бусийн өмчлөлт, зөвлөхөөр төрийн орлогч дарга 3. Аймгийн нэгдсэн эмчлэлийн дарга	
3.			ТҮСМ-7	1. Аймгийн нэгдсэн эмчлэлийн орлогч дарга 2. Дүүргийн нэгдсэн эмчлэл, Эрүүл мэндийн нэгдлийн дарга 3. Аймгийн зорилготой хотын нэгдсэн эмчлэлийн дарга	1. Улсын өмчийн болон төрөлхөн маргажлийн зөвлөлийн захирал эвч 2. Бусийн өмчлөлт, зөвлөхөөр төрийн орлогч эвч
4.			ТҮСМ-6	1. Дүүргийн нэгдсэн эмчлэл, Эрүүл мэндийн нэгдлийн орлогч дарга 2. Сүх, сум дундын эмчлэлийн дарга 3. Эмчлэлийн чиглэлээр мэргэжил	1. Нэгдсэн эмчлэлийн захирал эвч
5.	Маргажлийн албан тушаал	Тодорхой нэрийн маргажлийн эвчлэл, үр чадвар, туршлага шаардах ажил эрхэлдэг, тухайн маргажлийн бие даан эмчлэгчид буюу эмчлэлийн санхүүг төрөөдөр шаардах санхүү, эмчлэлт гаргах үүрэг бүхий албан тушаал	ТҮСМ-6	1. Улсын өмчийн болон төрөлхөн маргажлийн зөвлөлийн их эмч, эмчлэл, эрүүл байр их эмч, нийгмийн эрүүл мэндийн маргажлийн 2. Бусийн өмчлөлт, зөвлөхөөр төрийн их эмч, эмчлэл, эрүүл байр их эмч, нийгмийн эрүүл мэндийн маргажлийн	
6.			ТҮСМ-4	1. Нэгдсэн эмчлэл, Эрүүл мэндийн нэгдэл, аймгийн зорилготой хотын нэгдсэн эмчлэлийн их эмч, эмчлэл, эрүүл байр их эмч, нийгмийн эрүүл мэндийн маргажлийн 2. Рашаан сууцлын их эмч, эмчлэл, эрүүл байр их эмч 3. Сүх, сум дундын эмчлэлийн их эмч	
7.			ТҮСМ-3	1. Ерөнхий сувилагч 2. Дэлгэрэнгүй эмч 3. Сувилагчийн эрхлэл 4. Эм баруун бага эмч 5. Бага эмч	
8.			ТҮСМ-2	1. Сувилагч 2. Бага эмч 3. Эмчлэл 4. Эмчлэлээр бусад туршигч эмчлэлийн 5. Ариун тусгаарлах, урьдчилсан 6. Эмчлэлээр бусад туршигч эмчлэл	
9.	Төрийн үйлчилгээний албан тушаал	Зайруулах үйлчилгээний зөвлөхөөр төрийн үйлчилгээний албан тушаал, үйлчилгээний албан тушаал, үйлчилгээний албан тушаал	ТҮСМ-1	1. Ариун тусгаарлах, урьдчилсан 2. Эмчлэлээр бусад туршигч эмчлэл	

Засгийн газрын 2007 оны 236 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын ангилал	Тухайн ангилалд зааагдсан албан тушаалын тэвчээрэйжилт	Зөрүүлэл	Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал
1	2	3	4	5
1	Урьдчилсан албан хаагч	Төрийн үйлчилгээний бие даасан байгууллагыг удирдаж, эрх зэмсэгийнхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаал	ТҮСУ-11	1. Эрдэмийн театр, чуулгын өрнөний зохиолч 2. Үндэсний номын сангийн зохиолч 3. Үндэсний түүхийн музейн зохиолч
2			ТҮСУ-10	1. Эрдэмийн театр, чуулгын дэд зохиолч 2. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, зохиолч 3. Эрдэмийн театр, чуулгын уран саймы урьддагч 4. Үндэсний номын сангийн дэд зохиолч 5. Үндэсний музейн дэд зохиолч
3			ТҮСУ-9	1. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, зохиолч 2. Эрдэмийн театр, чуулгын урьддагч, өрнөний найруулагч, өрнөний хөрөмжтэй, өрнөний багш, хөдөлгөөнт, өрнөний зураач 3. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын уран саймы урьддагч 4. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн зохиолч 5. Соёлын өвийн төвийн зохиолч 6. Хүүхдийн номын сангийн зохиолч 7. Улаанбаатар хот дахь төв номын сангийн зохиолч
4			ТҮСУ-8	1. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын өрнөний найруулагч, өрнөний урьддагч, өрнөний багш, хөдөлгөөнт, өрнөний хөрөмжтэй, өрнөний зураач 2. Эрдэмийн театр, чуулгын урьддагч, багш, найруулагч, багш, хөдөлгөөнт, хөрөмжтэй 3. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын уран саймы урьддагч 4. Орон нутаг дахь төв номын сангийн зохиолч 5. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн дэд зохиолч 6. Орон нутаг дахь төв музейн зохиолч 7. Улаанбаатар хот дахь төв номын сангийн дэд зохиолч
5			ТҮСУ-7	1. Орон нутаг дахь мэргэжлийн урлагийн байгууллагын өрнөний урьддагч, өрнөний найруулагч, өрнөний багш, хөдөлгөөнт, өрнөний хөрөмжтэй, өрнөний зураач, багш 2. Улаанбаатар хотын мэргэжлийн урлагийн байгууллагын удирдагч, найруулагч, багш, хөдөлгөөнт, хөрөмжтэй 3. Үндэсний номын сангийн номын дарга 4. Үндэсний музейн номын дарга 5. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн сан хөдөлгөөнт эрхлэгч 6. Улаанбаатар хот дахь дүүргийн номын сангийн эрхлэгч 7. Орон нутгийн музейн сан хөдөлгөөнт эрхлэгч 8. Орон нутаг дахь төв номын сангийн номын дарга 9. Хүүхдийн номын сангийн номын дарга
6			ТҮСУ-6	1. Улаанбаатар хот дахь мэргэжлийн урлагийн байгууллагын өргөжөөлөгч, дүүлэгч, жүжигчин, бүжигчин, хөдөлгөөнт, драматург, гэрлийн инженер, сценарийны зохиолч, зураач 2. Үндэсний номын сангийн арга зүй, ном зүй, эрдэм шинжилгээний ажилтан, өмнө номын сан, номын сангийн инженер, програмшист 3. Үндэсний музейн арга зүй, ном зүй, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөдөлгөөнт эрхлэгч 4. Улаанбаатар хот дахь улсын чанартай музейн бүртгэл мэдээллийн санх 5. Орон нутгийн музейн бүртгэл мэдээллийн санх
7			ТҮСУ-5	1. Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын өргөжөөлөгч, дүүлэгч, жүжигчин, туслах найруулагч, инженериймэстэр, драматург 2. Музей, соёлын өвийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан, куратор, арга зүйн, сүүлчийн инженер, сан найруулагч, лабораторийн эрхлэгч, сурган засварлагч-сүүлэгч, зураач-дизайнер, боловсролын ажилтан, инженерийн мастер 3. Номын сангийн ном зүйн, арга зүйн, ном бүрдүүлэгч, бүртгэл мэдээллийн номын санх, фондох, ном ажилтан, ном дотоодын, новор гар бичгийн-сурган засварлагч 4. Соёлын өвийн төвийн эрхлэгч 5. Соёлын өвийн сангийн эрхлэгч 6. Гэрлийн найруулагч, дүүлэгч найруулагч
8			ТҮСУ-4	1. Театр, чуулгын уран зохиолын ажилтан, нот багш, гэрлийн оператор, дууны оператор, өмнөний зохиолч, туслах зураач, өдгийн мастер 2. Орон нутгийн соёлын төвийн дүү, инженерийн багш, бүжгийн багш 3. Музейн хөдөлгөөнт, гэрлийн засварлагч, үйлчилгээний зохион байгуулагч 4. Номын сангийн үйлчилгээ үйлчилгээний номын санх 5. Театр, чуулгын фондын эрхлэгч 6. Талын, мэдээлэл 7. Гэрлийн инженер
9	Төлөөлөгч гүйцэтгэлтэн албан хаагч	Байгууллагын үйл ажиллагааг, зарилгыг биелүүлэхэд төдөрхөй мэргэжилтэн, боловсрол, ур чадвар шаардах ажил гүйцэтгэл үүрэг бүхий албан тушаал	ТҮСУ-3	1. Номын сангийн ном дарбан хаагч 2. Хүүр хураагч 3. Сценарийн, сүүлчийн, жүжгийн 4. Музейн тус бүрдүүлэгч
10			ТҮСУ-2	1. Хүүхдийн эрхлэгч 2. Тасалбар, туслахуулийн хаагч 3. Музейн үндэс инженер 4. Гэрлийн эрхлэгч 5. Туслахуулийн ажилтан
11			ТҮСУ-1	1. Санхүүжилт, өмчийн өргөжөөлөгч, эрхлэгч 2. Ном хураагч 3. Санхүүжилт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

Төрийн захиргааны албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг үндсэн цалинд нь шингээн тооцсонтой холбогдуулан "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 96 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар

баталсан "Төрийн захиргааны албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ын 3 дахь заалтын "10" гэснийг "0" гэж өөрчлөн 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 535 төгрөг 71 мөнгө буюу сард 90000 (ерэн мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 174 дүгээр тогтоолыг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

Ахмад дайчдын орон сууцны тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 2007 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд ахмадууд болон төрийн албан хаагчдад зориулан орон сууц барихаар тусгагдсан хөрөнгөөс өмнө нь улсаас орон сууц авч байгаагүй ахмад дайчдыг орон сууцаар хангах ажлыг энэ онд багтаан зохион байгуулж хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаярт үүрэг болгосугай.

2. Ахмад дайчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулж тодорхой хэмжээний хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусган шийдвэрлэж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх нөхцөлийг тусган уг асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг Барилга, хот байгуулалтын сайд

Ж.Наранцацралт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 254

Улаанбаатар
хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

2007 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Шуудан, цахилгаан холбоо, мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХСАЙХАН

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 256

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Усны тухай хуулийн 32.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

И.Эрдэнэбаатар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. "Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХСАЙХАН

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2007 оны 256 дугаар
тогтоолын хавсралт

ГАН, ЦӨЛЖИЛТ, ХУУРАЙШИЛТЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ БОЛОН ЭНЭ ҮЕД МӨРДӨХ УСНЫ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Зарим бүс нутагт тохиолдсон ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөц ашиглалтын горимыг тодорхойлоход энэхүү журмыг мөрднө.

2. Журмын зорилго нь ган, цөлжилт, хуурайшилт зэрэг уур амьсгалын сөрөг үзэгдлийн үед хүн ам, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн ус хангамжийг зохицуулан хангах, усны нөөцийг хадгалах замаар байгалийн тухайн үзэгдлийг хөхирэл багатай даван туулахад оршино.

3. Ган, цөлжилт, хуурайшилтын үед баримтлах усны нөөцийн менежментийн журмыг нийслэл, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

4. Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэлийг холбогдох мэргэжлийн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон нийслэл, тухайн аймгийн Засаг даргын хамтарсан шийдвэрээр тогтооно.

Хоёр. Цөлжилт, цөлжилтийн зэрэглэл тогтоох

1. Цөлжилт гэж уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хуурай, хуурайвтар, чийг дутмаг бус нутгийн хөрсний үржил шим устаж доройтсоныг хэлнэ.

2. Монгол орны зарим бус нутагт тохиолдож байгаа цөлжилтийн эрчийг дараахь зэрэглэлд хуваана.

2.1. Сул цөлжилттэй нутаг;

2.2. Хүчтэй цөлжилттэй нутаг;

2.3. Нэн хүчтэй цөлжилттэй нутаг.

3. Цөлжилтийн зэрэглэл тогтоох саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавина.

4. Цөлжилтийн зэрэглэл тогтоох тухай саналд дараахь мэдээлэл, судалгааг хавсаргана:

4.1. Цөлжилтөд өртсөн нутгийн хил хязгаарыг харуулсан газрын зураг;

4.2. Тухайн нутагт сүүлийн 5 жилд унасан хур тунадасны тухай мэдээлэл (жилийн болон улирлын дүнгээр);

4.3. Сүүлийн 5 жилийн байдлаар салхи шуургатай байсан өдрийн тоог олон жилийн дундажтай харьцуулсан судалгаа (хувиар);

4.4. Тухайн нутгийн ургамлын бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлтийн судалгаа;

4.5. Гадаргын усны нөөцийн хувирал, өөрчлөлтийн судалгаа;

4.6. Газрын доорхи усны түвшингийн судалгаа;

5. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага цөлжилтийн зэрэглэл тогтоохоор гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг хүлээн авч дараахь арга хэмжээг авна:

5.1. Цөлжилтийн зэрэглэлийг нь тогтоохоор санал болгож байгаа бус нутагт газар зүй, хөрс, ус, цаг уурын чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг эрдэмтэд, ус, цаг уурын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллуулна;

5.2. Цөлжилтийн зэрэглэл тогтоох ажлын хэсгээс цөлжилтийн зэрэглэл тогтоосон дүгнэлтэд үнэлгээ өгөх шинжээчдийн баг томилон үнэлгээ хийлгэнэ;

5.3. Ажлын хэсгийн дүгнэлт болон үнэлгээний дүнг үндэслэн тодорхой бүс нутгийн цөлжилтийн зэрэглэлийг тогтооно.

6. Цөлжилтөд өртсөн бус нутагт усны нөөц ашиглалт, хамгаалалтын дараахь горимыг мөрдөнө:

6.1. Сул цөлжилттэй нутагт:

6.1.1. хүн амын унд, ахуйн болон мал сүрэг, тэжээвэр амьтдын усны хэрэглээг зохистой шаардлагын хэмжээнд зөвшөөрнө;

6.1.2. аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж болох усны дээд хэмжээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгж бүрээр хянан, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хязгаарлалтыг тогтооно;

6.1.3. усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны албаны гаргасан ус ашиглуулах мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга аж ахуйн нэгж бүртэй ус ашиглуулах гэрээ байгуулж ажиллана.

6.2. Хүчтэй цөлжилттэй нутагт:

6.2.1. энэ журмын 6.1-д заасан ус ашиглалтын горимыг мөрдөнө;

6.2.2. шаардлагатай бол энэ журмын 6.1.1-д заасан зориулалтаар гадаргын ус ашиглуулахыг хориглох, хэсэгчлэн хязгаарлах горимыг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба гаргаж мөрдүүлнэ.

6.3. Нэн хүчтэй цөлжилттэй нутагт:

6.3.1. нэн хүчтэй цөлжилттэй нутагт энэ журмын 6.1.1-д заасан зориулалтаар ашиглах усны хэмжээнд хязгаарлалт тогтоох эсэх асуудлыг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба зохицуулан шийдвэрлэнэ.

6.3.2. аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар ус ашиглуулахыг тодорхой хугацаагаар хориглох шийдвэрийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргана.

7. Энэ журмын 6.2, 6.3-т заасан зэрэглэлийн цөлжилттэй нутагт газрын доорхи усны хайгуул, судалгаа хийх, уст цэг гаргаж тоноглох ажлын талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тодорхой санал боловсруулан улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8. Цөлжилтөд өртсөн нутгийн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үүрэг:

8.1. Хүчтэй болон нэн хүчтэй цөлжсөн нутагт хиймэл цөөрөм, хөв байгуулах, булаг шандын эх, баянбүрдийг хамгаалан тохижуулах, ойжуулах ажил зохион байгуулах;

8.2. Хүчтэй болон нэн хүчтэй цөлжсөн нутагт ус ашиглалтын горимын хэрэгжилтийг хянан зохион байгуулах;

8.3. Цөлжилтөд нэрвэгдсэн бүс нутагт усыг хэмнэлттэй, дахин ашиглах технологи, усан орчинг нөхөн сэргээсэн үйл ажиллагааг дэмжих бодлого баримтлан, зохицуулалтын арга хэмжээ авах;

8.4. Цөлжилтийг идэвхижүүлэх нөлөө бүхий мал сүргийн төрөл, тоо хэмжээг тодорхой хугацаагаар хязгаарлах, зохистой байршуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглох талаар холбогдох арга хэмжээ авах.

Гурав. Ган

1. Ган гэж ургамал ургах хугацаанд удаан хугацаагаар хур тунадас ороогүйн улмаас ус зүйн тэнцвэр алдагдан, газрын гадарга хатаж ургамлын нөмрөг мөхөж байгаа улирлын давтамжтай үртэлжлэх байгалийн үзэгдлийг хэлнэ.

2. Ганг дараахь зэрэглэлээр ангилна.

- 2.1 Гандуу;
- 2.2 Гантай;
- 2.3 Улаан ган.

-Дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 30-аас дээш хувиар багассан бүс нутгийг гандуу.

-Дулааны улиралд орох хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 50-аас дээш хувиар багассан бүс нутгийг гантай.

-Дулааны улиралд хур тунадас огт ороогүйн улмаас ургамлын ургалт зогсож, булаг шанд, цөөрөм, баянбүрд зэрэг гадаргын усны эх үүсвэр ширгэснийг улаан ган гэнэ.

3. Гангийн зэрэглэл тогтоох тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавина. Гантай нутаг нь хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарч байвал тэдгэр аймгийн Засаг дарга нар саналаа хамтран тавьж болно.

4. Гангийн зэрэглэл тогтоох тухай саналд дараахь мэдээлэл, судалгааг хавсаргана:

4.1. Гантай байгаа нутгийн хил хязгаарыг харуулсан газрын зураг;

4.2. Тухайн жилийн дулааны улиралд гантай гэгдэж байгаа нутагт орсон хур тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулсан судалгаа;

4.3. Ургамалжилтын байдал, байгалийн ургамлын ургалтын үе шатны тухай мэдээлэл;

4.4. Гол мөрөн, нуур зэрэг гадаргын усны түвшин, урсацад гарсан өөрчлөлт зэрэг гадаргын усны байдлын судалгаа;

4.5. Хатаж ширгэсэн булаг шанд, нуур, цөөрмийн тухай мэдээлэл.

5. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг судалж гангийн зэрэглэл тогтоох нөхцөл байдал бий болсон гэж үзвэл гангийн байдлыг судлах ажлын хэсгийг тухайн нутагт томилон ажиллуулна. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан тушаалтан болон цаг уур, ус, хөрс, ургамал судлалын мэргэжилтнүүдийг оруулна.

Гангийн зэрэглэл тогтоохоор томилогдсон ажлын хэсгийн дүнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тодорхой бүс нутагт гангийн зэрэглэл тогтооно.

6. Гантай нутагт мөрдөх ус ашиглалт, хамгаалалтын бүсийн дэглэм тогтоосон журмыг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн байгаль орчин болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан



төрийн захиргааны төв байгууллага батлан мөрдүүлнэ.

7. Гантай нутагт усны нөөцийг их хэмжээгээр ашигладаг аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглалтыг түр хугацаагаар хязгаарлах шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга гаргаж болно.

Доров. Хуурайшилт

1. Хуурайшилт гэж хур тунадасны хэмжээ болон ургамал, хөрсний нийлбэр чийгшлийн ууршилтын хоорондын харьцаа нь 0.05-0.65 хооронд хэлбэлзэж, агаарын чийглэг эрс багассан улирлын давтамжтай үзэгдлийг хэлнэ.

2. Хуурайшилтын индекс тодорхойлох аргачлалыг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

3. Хуурайшилтын зэрэглэлийг дараахь байдлаар тогтооно:

3.1. Хуурайшилтын индексийн утга нь 0.05-аас бага байгаа тохиолдлыг хэт хуурайшилттай;

3.2. Хуурайшилтын индексийн утга нь 0.05-0.20 бол хуурайшилттай;

3.3. Хуурайшилтын индексийн утга нь 0.20-0.50 бол хуурайвтар;

3.4. Хуурайшилтын индексийн утга нь 0.50-0.65 бол чийг дутагдалтай гэж үзнэ.

4. Хуурайшилттай нутгийн зэрэглэлийг цаг уур, орчны шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилогдсон шинжээчдийн баг тодорхойлон тогтооно.

5. Тандан судалгаа хийх, дээж, сорьц шинжлэх, харуул ажиглалтын дүн мэдээг нэгтгэн судлах аргаар шинжээчдийн баг хуурайшилтын зэрэглэлийг аймаг бүрээр жил бүрийн 3 дугаар сарын 15-наас 6 дугаар сарын 1, 9 дүгээр сарын 1-

нээс 11 дүгээр сарын 1-ний хооронд 10 хоног тутам тодорхойлно.

6. Шинжээчдийн багийн дүгнэлтээр хуурайшилттай болон хэт хуурайшилтын зэрэглэлд хамрах хээрийн, ойт хээрийн бүс нутгийг сум бүрээр тодорхойлж, хуурайшилтаас үүсэх үр дагавраас сэргэмжлүүлэх арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэх үүргийг цаг уур, орчны шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

7. Хуурайшилттай үед мөрдөх усны нөөц ашиглалтын нийтлэг горимыг хуурайшилтын зэрэглэл, бүс нутгийн онцлог, аж ахуйн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба батлан мөрдүүлнэ.

8. Хуурайшилтын үед мөрдөх усны нөөц ашиглалтын нийтлэг горимыг үндэслэж хуурайшилттай нутгийн онцлог, гал түймрээс хамгаалах шаардлага, хүн ам, мал сүргийн усан хангамжийн хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байхад чиглэгдсэн усны нөөц ашиглалтын тодорхой горимыг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоож болно.

9. Хуурайшилттай үед хүн амын унд, ахуйн болон мал сүрэг, ам амьтны усан хангамжийг хэвийн хангах зорилгоор тодорхой аж ахуйн нэгжүүдэд ус ашиглуулахыг сараас илүүгүй хугацаагаар хязгаарлах, хориглох шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг дарга гаргаж болно.

10. Хуурайшилттай болон хэт хуурайшилттай зэрэглэлд хамаарч байгаа нутгийн иргэдэд усны нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах, ой, хээрийн түймэр гарах зэрэг болзошгүй хүндрэлээс сэргэмжлүүлэх арга хэмжээг тухайн нутгийн баг, хорооны Засаг дарга хариуцан зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 258

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр-ийг баталсугай.

2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

М.ЭНХСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.ТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 26.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 214 дүгээр тэгтгоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-д дараахь агуулгатай 3.1.8, 3.3.7, 3.3.8, 3.4.4, 3.4.5 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

а/ "3.1.8. оршин сууж байсан нутаг дэвсгэрийн цэргийн штабын цэргийн бэлтгэл үүрэгтний бүртгэлээс хасуулсан тухай тодорхойлолт."

б/ "3.3.7. засаг захиргааны нэгжийн хооронд шилжин явсан, ирсэн иргэний хувийн хэргийг 30 хоногийн дотор холбогдох аймаг, нийслэл, дүүргийн иргэний бүртгэл, мэдээллийн алба тухайн иргэний шилжин очсон нутаг дэвсгэрийн иргэний бүртгэл, мэдээллийн албанд хүргүүлнэ;"

в/ "3.3.8. тухайн засаг захиргааны нэгжид шилжин ирээд тодорхой хаягаар суурьшсан, шилжүүлгээ албан ёсоор хийлгээгүй, өөрийн биеэр очих санхүүгийн боломжгүй энэхүү журмын 2.4-т заасан шилжин суурьшихыг түр хойшлуулах үндэслэлгүй иргэний хувийн хэргийг тухайн иргэний хүсэлтийг үндэслэн оршин сууж байгаа газрын иргэний бүртгэлийн байгууллагын албан ёсны хүсэлтээр шилжүүлж өгнө;"

г/ "3.4.4. гадаад улсад 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа тухайгаа Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлсэн Монгол Улсын иргэний тухай мэдээллийг Гадаад хэргийн яам цахим сүлжээгээр тухай бүр Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд ирүүлнэ;"

д/ "3.4.5. цэргийн алба хаяж байгаад

халагдсан иргэний бүртгэлийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх цэргийн штаб, хорих ял эдэлж байгаад суллагдсан иргэний бүртгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гаргаж төв, орон нутгийн иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагад хүргүүлнэ."

2. Мөн журмын 1.3-т "Харин батлан хамгаалах, тагнуул, хил хамгаалах, гааль, төмөр зам, цагдаагийн байгууллагын шийдвэрээр 1 жилээс дээш хугацаагаар засаг захиргааны өөр нэгжид ажиллахаар томилогдсон иргэн тухайн оршин суух нутаг дэвсгэрийн иргэний бүртгэлийн албанд бүртгүүлж, иргэний үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ." гэсэн 2 дахь хэсэг, мөн журмын 3.3.1-д "Түр оршин суух үнэмлэхийн загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэсэн 2 дахь хэсэг, мөн журмын 2.4.4-ийн "ажиллаж байсан" гэсний дараа "татвар, банк, санхүүгийн" гэж, мөн журмын 3.3.1-ийн "... гэсэн тэмдэглэлийг заавал хийж" гэсний дараа "Түр оршин суух үнэмлэхийг иргэнд олгох бөгөөд" гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 3.1.6-г "батлан хамгаалах, тагнуул, хил хамгаалах, гааль, төмөр зам болон цагдаагийн байгууллагын албан хаагч бол томилогдсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр" гэж, мөн журмын 3.3.3-ыг "бүх шатны сургуулийн удирдлага хичээлийн шинэ жил эхэлснээс хойш 1 сарын дотор засаг захиргааны бусад нэгжээс шилжин суралцагч иргэдийн овог, нэр, оршин суугаа хаягийн бүртгэлийг тухайн аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж хүн амын бүртгэлд бүрэн хамруулах арга хэмжээ авна." гэж тус тус өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**
Д.ОДБАЯР

 Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
 Хаяг: <<Төрийн мэдээлэл>> зөмтгөлийн зөвөл.

 Улсын Их Хурлын Тамгын газрын
 Хөдөлжээс хэвлэв

 Улаанбаатар: 12
 Төрийн ордон

 ☎ 260000
 Идэвх: 14003

☎ 320487

Хэвлэлийн хуудал: 3